



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 4 сарын 04 өдөр

Дугаар 141

Улаанбаатар хот

Банк бус санхүүгийн гадаад валютын  
арилжаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй  
болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эбо инвест ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн гадаад валютын арилжаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. “Эбо инвест ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн гадаад валютын арилжааны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд холбогдох өөрчлөлтийг хийлгэхийг “Эбо инвест ББСБ” ХХК /М.Хонгорзул/-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийт болон харьяалагдах татварын алба, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт ажлын 10 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН